



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан аймгийн Уламжлалт анагаах ухааны төвийн 2023 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/03/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улиастай сум
2024 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежер : Х.Болдбаатар

Утас:99105506

Цахим хаяг: BoldbaatarKh@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Оюунсүвд

Утас: 99076038

Цахим хаяг: oyunsuvdts@audit.gov.mn

Аудитор : Г.Уранбаяр

Утас:95183025

Цахим хаяг:gonchigdorjuranbayr@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	
16	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт



**ЗАВХАН АЙМГАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

81090 Улаангай, Завхан аймаг
Утас/Факс: 7046-36-12
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

ЗАВХАН АЙМГИЙН УЛАМЖЛАЛТ
АНАГААХ УХААНЫ ТӨВИЙН ДАРГА
Д.ӨЛЗИЙБАЯР-Т

2024.02.22 № 92

Талай _____ -ны № _____

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Завхан аймгийн Уламжлалт анагаах ухааны төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ

Завхан аймгийн Уламжлалт анагаах ухааны төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Завхан аймгийн Уламжлалт анагаах ухааны төв нь эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээс 938.7 сая төгрөгийг төвлөрүүлэн зарцуулсан байна. Төсвийн хөрөнгөөр 17.3 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 28.5 сая төгрөгийн хөрөнгө шийдвэрийн дагуу данснаас хассан байна. Тайлант онд 221.9 сая төгрөгийн материал худалдан авч 206.6 сая төгрөгийн материалыг баримтын дагуу зарцуулж, 17.4 сая төгрөгийн материалыг акталж, устгасан байна.

Аудитын гол асуудал

Завхан аймгийн Уламжлалт анагаах ухааны төв нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан тодруулгуудад дүгнэлт өгөх аудитаар зөрчил илрээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Завхан аймгийн Уламжлалт анагаах ухааны төв нь 8.3 сая төгрөгийн хөрөнгөнд дахин үнэлгээ хийж бүртгэлд тусгасан байна. Шилэн дансны цахим мэдээллийн системд байгууллагын урсгал санхүүжилт, хөрөнгө зарцуулах шийдвэрүүдийг тухай бүр мэдээлсэн байна.

017020133

Audit(D)Дүгнэлт/2024

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	85,796,125.45	123,160,765.67
2	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	(0.00)	893,797.33
8	Банкинд байгаа бэлэн мөнгө	(0.00)	893,797.33
16	Гадаад валютаар	(0.00)	893,797.33
17	Төрийн сангийн харилцах	(0.00)	893,797.33
27	АВЛАГА	-	38,597,949.34
28	Ажиллагсадтай холбогдсон авлага	-	233,549.34
29	Төлбөртэй үйлчилгээний авлага	-	38,335,500.00
34	Бусад авлага	-	28,900.00
35	Байгууллагаас авах авлага	-	28,900.00
60	БАРАА МАТЕРИАЛ	85,796,125.45	83,669,019.00
61	Түүхий эд материал	49,101,215.45	48,140,693.00
62	Тусгай зориулалттай материал	16,714,344.45	8,630,025.00
63	Эм боох материал	32,386,871.00	39,510,668.00
66	Хангамжийн материал	36,694,910.00	35,528,326.00
67	Бичиг хэргийн материал	1,066,180.00	1,272,590.00
68	Аж ахуйн материал	32,346,200.00	28,859,900.00
70	Түлш шатах тослох материал	-	69,136.00
71	Барилгын засварын материал	1,348,450.00	561,200.00
72	Хүнсний материал	1,494,940.00	4,326,360.00
73	Бусад хангамжийн материал	439,140.00	439,140.00
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	529,809,882.42	521,747,802.39
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	529,809,882.42	521,747,802.39
108	Биет хөрөнгө	510,546,882.38	504,234,802.31
109	Барилга, байгууламж	500,000,000.00	500,000,000.00
110	Хуримтлагдсан элэгдэл	(41,666,666.76)	(55,555,555.68)
111	Авто тээврийн хэрэгсэл	5,337,499.83	5,337,499.83
112	Хуримтлагдсан элэгдэл	(4,225,520.58)	(5,337,499.83)
113	Машин, тоног төхөөрөмж	105,766,666.58	75,300,170.40
114	Хуримтлагдсан элэгдэл	(73,882,787.09)	(35,295,880.13)
115	Тавилга, аж ахуйн эд хогшил	40,701,091.18	34,693,675.00
116	Хуримтлагдсан элэгдэл	(21,483,400.78)	(19,028,440.63)
122	Бусад үндсэн хөрөнгө	950,000.00	5,250,000.00
123	Хуримтлагдсан элэгдэл	(950,000.00)	(1,129,166.65)
126	Биет бус хөрөнгө	19,263,000.04	17,513,000.08
127	Програм хангамж	7,462,000.00	7,462,000.00
128	Хасагдуулга	(2,211,999.96)	(3,961,999.92)
129	Бусад биет бус хөрөнгө	14,013,000.00	14,013,000.00
137	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	615,606,007.87	644,908,568.06
138	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	(0.00)	34,166,101.01
139	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	(0.00)	34,166,101.01

164	Өглөг	(0.00)	34,166,101.01
165	Ажиллагчидтай холбогдсон өглөг	(0.00)	2,226,197.61
170	Бусад өглөг	-	31,939,903.40
171	Байгууллагад төлөх өглөг	-	31,631,903.40
172	Хувь хүмүст төлөх өглөг	-	308,000.00
214	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	615,606,007.87	610,742,467.05
215	Засгийн газрын хувь оролцоо	615,606,007.87	610,742,467.05
216	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	52,541,504.54	52,541,504.54
217	Өмч: -Төрийн өмч	52,541,504.54	52,541,504.54
223	Хуримтлагдсан үр дүн	562,231,758.53	557,997,868.71
224	Өмнөх үеийн үр дүн	562,231,758.53	562,861,409.53
225	Тайлант үеийн үр дүн	-	(4,863,540.82)
227	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	832,744.80	203,093.80
231	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	615,606,007.87	644,908,568.06

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	604,395,256.00	984,230,950.00
76	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23,076,452.00	45,511,100.00
77	Нийтлэг татварын бус орлого	23,076,452.00	45,511,100.00
81	Төсөвт байгууллагын өөрийн орлого	23,076,452.00	45,511,100.00
82	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,076,452.00	35,621,100.00
86	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	9,890,000.00
111	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	581,318,804.00	938,719,850.00
143	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс	581,318,804.00	938,719,850.00
145	Эрүүл мэндийн даатгалын сангаас	581,318,804.00	938,719,850.00
147	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	691,006,361.73	988,637,823.78
148	УРСГАЛ ЗАРДАЛ	691,006,361.73	988,637,823.78
149	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	690,646,361.73	988,137,823.78
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	342,170,939.76	567,633,786.29
151	Цалин	213,748,839.91	313,707,614.15
152	Нэмэгдэл цалин	90,617,306.45	183,465,865.83
153	Унаа хоолны хөнгөлөлт	11,758,000.00	22,370,000.00
154	Урамшуулал	26,046,793.40	48,090,306.31
157	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,220,170.51	70,849,993.06
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	29,548,636.36	48,324,775.48
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,476,309.61	5,685,267.68
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,764,247.68	4,548,214.04
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	667,643.03	1,135,515.47
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	6,763,333.83	11,156,220.39
164	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,831,514.94	70,953,805.01
165	Гэрэл цахилгааны зардал	9,869,294.94	15,962,844.01
166	Түлш, халаалтын зардал	40,441,500.00	41,739,371.00
167	Цэвэр, бохир усны зардал	9,520,720.00	13,251,590.00

170	Хангамж, бараа материалын зардал	36,761,432.00	56,115,982.88
171	Бичиг хэргийн материал	4,710,340.00	4,062,960.00
172	Тээвэр, шатахууны зардал	1,647,361.00	1,489,706.00
173	Шуудан холбоо интернетийн төлбөр	2,072,681.00	2,258,997.43
175	Хог хаягдал устгах, цэвэрлэх	1,592,200.00	3,965,200.00
176	Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	26,738,850.00	34,624,300.00
178	Бараа материал актасны зардал	-	9,714,819.45
181	Нормативт зардал	97,228,815.46	145,378,886.00
182	Эм	43,430,045.43	68,673,446.00
183	Хоол	49,354,770.03	74,183,440.00
184	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,444,000.00	2,522,000.00
185	Эд хогшил, урсгал засварын зардал	71,848,602.00	28,835,450.00
188	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	3,947,102.00	1,390,100.00
189	Урсгал засвар	67,901,500.00	27,445,350.00
190	Томилолт, зочны зардал	159,000.00	1,689,600.00
192	Дотоод томилолтын зардал	159,000.00	1,689,600.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	6,692,204.65	11,843,007.55
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,924,730.00	7,262,190.00
196	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,180,000.00	1,500,000.00
198	Тээврийн хэрэгслийн татвар	-	46,110.00
200	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	2,447,344.65	2,879,007.55
201	Газрын төлбөр	140,130.00	155,700.00
209	Бараа үйлчилгээний бусад зардал	32,733,682.41	34,837,312.99
212	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	32,733,682.41	34,837,312.99
224	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	360,000.00	500,000.00
228	Бусад урсгал шилжүүлэг	360,000.00	500,000.00
236	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	360,000.00	500,000.00
269	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III-I-II)	(86,611,105.73)	(4,406,873.78)
277	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЫН ДҮН (V)	-	456,667.04
278	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	456,667.04
288	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI-IV-V)	-	(456,667.04)
289	НИЙТ ҮР ДҮН (VII-III+VI)	(86,611,105.73)	(4,863,540.82)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
77	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	23,076,452.00	35,621,100.00
78	Нийтлэг татварын бус орлого	23,076,452.00	35,621,100.00
82	Төсөвт байгууллагын өөрийн орлого	23,076,452.00	35,621,100.00
83	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,076,452.00	35,621,100.00
110	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	749,107,428.60	900,384,350.00
143	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	749,107,428.60	900,384,350.00
144	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	167,788,624.60	-
145	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	581,318,804.00	900,384,350.00
147	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	759,539,375.60	928,359,752.67
148	УРСГАЛ ЗАРДАЛ	759,539,375.60	928,359,752.67

149	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	759,179,375.60	927,859,752.67
150	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	335,431,580.98	561,774,331.08
151	Үндсэн цалин	176,678,908.98	239,491,053.25
152	Нэмэгдэл	121,504,047.60	240,800,183.09
153	Унаа хоолны хөнгөлөлт	11,820,000.00	22,079,640.28
154	Үр дүнгийн урамшуулал	25,428,624.40	59,403,454.46
157	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	48,946,400.00	74,716,800.00
158	Тэтгэврийн даатгалын шимтгэл	33,283,600.00	50,807,400.00
159	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,915,700.00	5,977,300.00
160	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,132,600.00	4,781,900.00
161	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	783,100.00	1,195,500.00
162	Эрүүл мэндийн даатгалын хураамж	7,831,400.00	11,954,700.00
164	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	83,711,514.94	62,825,519.61
165	Гэрэл цахилгааны зардал	9,869,294.94	14,441,378.61
166	Түлш, халаалтын зардал	64,321,500.00	36,236,621.00
167	Цэвэр, бохир усны зардал	9,520,720.00	12,147,520.00
170	Хангамж, бараа материалын зардал	46,887,795.00	33,136,409.43
171	Бичиг хэрэг	4,562,090.00	3,425,920.00
172	Тээвэр, шатахуун	1,406,022.00	1,761,142.00
173	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,072,681.00	2,258,997.43
175	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,764,200.00	4,793,400.00
176	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	34,082,802.00	20,896,950.00
181	Нормативт зардал	142,827,630.03	150,283,603.00
182	Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	77,978,120.03	69,925,343.00
183	Хоол, хүнс	47,953,410.00	71,966,260.00
184	Нормын хувцас, зөөлөн эдлэл	16,896,100.00	8,392,000.00
185	Эд хогшил, урсгал засварын зардал	77,714,800.00	30,970,600.00
186	Багаж техник хэрэгсэл	4,284,600.00	1,303,000.00
188	Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл	4,977,250.00	3,009,500.00
189	Урсгал засвар	68,452,950.00	26,658,100.00
190	Томилолт, зочны зардал	159,000.00	1,689,600.00
192	Дотоод албан томилолт	159,000.00	1,689,600.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	23,500,654.65	12,462,889.55
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	18,932,550.00	7,262,190.00
196	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,340,000.00	1,500,000.00
198	Тээврийн хэрэгслийн татвар	-	46,110.00
200	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,447,344.65	2,655,439.55
201	Газрын төлбөр	140,130.00	155,700.00
203	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	640,630.00	843,450.00
221	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	360,000.00	500,000.00
225	Бусад урсгал шилжүүлэг	360,000.00	500,000.00
233	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	360,000.00	500,000.00
251	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	12,644,505.00	7,645,697.33
252	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-

262	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	12,644,505.00	6,751,900.00
263	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,644,505.00	6,751,900.00
264	Дотоод эх үүсвэрээр	12,644,505.00	6,751,900.00
276	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	12,644,505.00	6,751,900.00
279	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(12,644,505.00)	(6,751,900.00)
280	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
304	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	893,797.33
305	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	(0.00)
306	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	(0.00)	893,797.33

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
9	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	52541504.54	832744.80	562231758.53	615606007.87
10	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	52541504.54	832744.80	562231758.53	615606007.87
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	629651.00	629651.00
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	52541504.54	832744.80	562861409.53	616235658.87
17	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0.0	0.0	-4863540.82	-4863540.82
18	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	52541504.54	203093.80	557997868.71	610742467.05

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,003,954,500.00	935,111,652.67
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,003,954,500.00	935,111,652.67
4	Бараа, үйлчилгээний зардал	1,003,454,500.00	934,611,652.67
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	597,734,000.00	561,774,331.08
6	Үндсэн цалин	221,442,100.00	239,491,053.25
7	Нэмэгдэл	279,609,600.00	240,750,183.09
8	Унаа, болон бусад нөхөн олговор	15,840,000.00	22,129,640.28
9	Урамшуулал	80,842,300.00	59,403,454.46
11	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	74,716,800.00	74,716,800.00
12	Тэтгэврийн даатгал	50,807,400.00	50,807,400.00
13	Тэтгэмжийн даатгал	5,977,300.00	5,977,300.00
14	ҮОМШӨ ний даатгал	4,781,900.00	4,781,900.00
15	Ажилгүйдлийн даатгал	1,195,500.00	1,195,500.00
16	Эрүүл мэндийн даатгал	11,954,700.00	11,954,700.00
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	72,728,200.00	62,825,519.61

18	Гэрэл цахилгаан	16,336,200.00	14,441,378.61
19	Түлш, халаалт	42,670,000.00	36,236,621.00
20	Цэвэр, бохир ус	13,722,000.00	12,147,520.00
22	Хангамж, бараа материалын зардал	36,160,800.00	33,158,009.43
23	Бичиг хэрэг	3,790,000.00	3,425,920.00
24	Тээвэр (шагахуун)	2,180,800.00	1,761,142.00
25	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	2,940,000.00	2,258,997.43
27	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,150,000.00	4,793,400.00
28	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	22,100,000.00	20,918,550.00
30	Нормативт зардал	159,840,700.00	150,283,603.00
31	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	71,403,900.00	69,925,343.00
32	Хоол, хүнс	80,036,800.00	71,966,260.00
33	Нормын хувцас зөөлөн эдлэл	8,400,000.00	8,392,000.00
34	Эд хогшил худалдан авах	46,573,200.00	37,700,900.00
35	Багаж, техник, хэрэгсэл	15,450,000.00	8,033,300.00
37	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	4,400,000.00	3,009,500.00
38	Урсгал засвар	26,723,200.00	26,658,100.00
39	Томилот, зочны зардал	2,060,000.00	1,689,600.00
41	Дотоод албан томилот	2,060,000.00	1,689,600.00
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	13,640,800.00	12,462,889.55
44	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,700,000.00	7,262,190.00
45	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,500,000.00	1,500,000.00
46	Даатгалын үйлчилгээ	90,000.00	-
47	Тээврийн хэрэгслийн татвар	85,000.00	46,110.00
48	Тээврийн хэрэгслийн оношилгоо	45,000.00	-
49	Мэдээллийн технологийн зардал	2,940,000.00	2,655,439.55
50	Газрын төлбөр	720,600.00	155,700.00
51	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	475,200.00	843,450.00
53	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	85,000.00	-
66	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	500,000.00	500,000.00
70	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	500,000.00
78	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	500,000.00	500,000.00
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,003,454,500.00	935,855,450.00
106	НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	975,454,500.00	900,384,350.00
109	Нийгмийн даатгалын сангаас эмнэлэгүүдэд олгох	975,454,500.00	900,384,350.00
110	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	28,000,000.00	35,471,100.00
111	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	28,000,000.00	35,471,100.00
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	893,797.33
129	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-
130	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	18.00	19.00
134	Удирдах ажилтан	1.00	1.00
135	Гүйцэтгэх ажилтан	11.00	12.00
136	Үйлчлэх ажилтан	6.00	6.00

138	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	-	-
148	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Завхан аймгийн Уламжлалт анагаах ухааны төв нь Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгаар зөвшөөрлийн дагуу тусламж үйлчилгээ явуулдаг. **Эрхэм зорилго:** Уламжлалт анагаах ухаан эмчилгээ үйлчилгээний цогц төв болно. **Зорилт:** Монголын уламжлалт анагаах ухааны түүхэн зүй тогтлыг алдагдуулахгүйгээр өнөөгийн шинэ шатанд гаргаж уламжлалт анагаах ухаан эмчилгээ үйлчилгээний цогц төв болж, иргэдэд уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хүргэх зорилт тавин ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналтын зөвлөл нь 2023 оны ажлын төлөвлөгөөндөө 5 ажил хийхээр төлөвлөсөн байна. Төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт бүрд удирдамж батлуулж, хяналтаар илэрсэн зөрчлийг арилгаж ажилласан байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан аймгийн Уламжлалт анагаах ухааны төвийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Завхан аймгийн Уламжлалт анагаах ухааны төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10,189.19 мянган төгрөгөөр буюу 1.6 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	85,796.13	83,669.02	(2,127.11)
Үндсэн хөрөнгө	529,809.88	521,747.80	(8,062.08)
Нийт хөрөнгө	615,606.01	605,416.82	(10,189.19)
Өр төлбөр	-	34,166.10	34,166.10
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	615,606.01	610,742.47	(4,863.54)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	615,606.01	644,908.57	29,302.56

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайланд онд

Бараа материалын эхний үлдэгдэл 85,796.1 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 221,979.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, зарцуулсан 206,670.0 мянган төгрөг, акталсан 17,436.1 мянган төгрөгөөр тус тус хасагдаж, эцсийн үлдэгдэл 83,669.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 2,127.11 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн хувьд төсвийн хөрөнгөөр 17,341.9 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хөрөнгө оруулалтаар 1,500.0 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр хүлээн авч элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжтой хөрөнгүүдэд үнэ тогтоож 8,390.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. 28,564.2 мянган төгрөгийн хөрөнгө актлах шийдвэр гарч хасагдаж, жилийн эцэст 642,056.3 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 34,837.3 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Богино хугацаат өр төлбөр 34,166.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь татвар болон бараа үйлчилгээний зардлын өглөг байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 4,863.54 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 975,454.5 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагаанаас 28,000.0 мянга нийт зарлагыг 1,003,454.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэхээр 975,454.5 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 900,384.3 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 35,471.1 мянган төгрөгийг санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 935,111.6 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 900,384.35 мянган төгрөг буюу 92.3 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг ажиллагсадтай холбоотой зардал 35,959.6 мянган төгрөг, байр ашиглахтай холбоотой тогтмол зардлаас 9,902.6 мянган төгрөг, хангамж бараа материалын зардал 3,002.7 мянган төгрөг, нормативт зардлаас 9,557.0 мянган төгрөгийг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Хөтөлбөр арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
Улсын төсвөөс санхүүжих					
71601					
80101	Нийгмийн эрүүл мэнд	975,454.5	900,384.3	75,070.2	92.3
НИЙТ		975,454.5	900,384.3	75,070.2	92.3

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр санхүүжсэн хөтөлбөр арга хэмжээ байхгүй.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

/Мянган төгрөг/

№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	Шууд худалдан авалт	Үйлчлүүлэгчдийн хоол-Мах	41,700.00	37,282.60
2	Шууд худалдан авалт	Үйлчлүүлэгчдийн – Хүнсний ногоо	10,650.00	9,521.20
3	Шууд худалдан авалт	Үйлчлүүлэгчдийн хоол-Сүү, цагаан идээ	12,000.00	8,150.20
4	Шууд худалдан авалт	Үйлчлүүлэгчдийн хоол-бусад хүнсний материал	15,686.80	17,012.20

5	Шууд гэрээ байгуулах	Түлш халаалт	42,670.00	36,236.60
6	Шууд гэрээ байгуулах	Гэрэл цахилгаан	16,336.20	14,441.30
7	Шууд гэрээ байгуулах	Цэвэр, бохир ус	13,722.00	12,147.50
8	Шууд худалдан авалт	Урсгал засвар	26,723.20	26,658.10
9	Шууд худалдан авалт	Харилцаа холбооны зардал	2,940.00	2,655.40
	ДҮН		140,728.20	126,822.50

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Завхан аймгийн Уламжлалт анагаах ухааны төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Аудитыг “Хаан соёмбо аудит” ХХК-ийн гэрээт аудитор Г.Уранбаяр гүйцэтгэж, хяналтыг “Хаан соёмбо аудит” ХХК-ийн захирал Х.Диймаа анхан шатанд хянаж, Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд, аудитын менежер Х.Болдбаатар нар хоёр дахь шатанд, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа дараагийн шатанд хяналтыг хэрэгжүүлсэн.

Завхан аймгийн Уламжлалт анагаах ухааны төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Хаан соёмбо аудит” ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн бусад үйл ажиллагааны мөнгөн орлогын 691,006.3 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 7,721.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,405.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 29 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2023 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завхан аймгийн Уламжлалт анагаах ухааны төвийн 2023 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Тайлант оны төгсгөлд дээд шатны төсөв захирагчаас цалин, нийгмийн даатгал болон хоолны зардлууд дээр төсөвт шаардлагагүй санхүүжилт нэмж олгосон байгааг дараагийн аудитаар анхаарч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй

5.2 Албан шаардлага хүргүүлээгүй

5.3 Зөвлөмж хүргүүлээгүй

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн н акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалт ны тоо	Тоо	Дүн	
Дүн													

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.БАТ-УНДРАА ОГНОО: 2024-02-22

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.БОЛДБААТАР ОГНОО: 2024-02-22

АХЛАХ АУДИТОР

Ц.ОЮУНСУВД ОГНОО: 2024-02-22

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ГЭРЭЭТ АУДИТОР

Г.УРАНБАЯР ОГНОО: 2024-02-22